ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр Дугаар 1/03 Улиастай

Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнээс захиалагчийн эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Эрх шилжсэн арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тайлагнахыг төсвийн захирагч нарт даалгасугай.

3.Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Чадраабал)-т зөвшөөрсүгэй.

4.Зорилт, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Азжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.ӨНӨРБАЯР

Захирамж-2024

8103010034

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 29 | Тэс сумын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрын дулаан алдагдлыг бууруулах | 2024 | 2024 | 80,000.0 | Тэс сумын Засаг дарга |
| 30 | Завханмандал сумын Хүнгийн голын ногоон хэрмийн бээрний сувиллыг засварлах | 2024 | 2024 | 150,000.0 | Завханмандал сумын Засаг дарга |
| 31 | Идэр сумын сургуулийн 60 хүүхдийн дотуур байрын барилгад их засвар хийх | 2024 | 2024 | 100,000.0 | Идэр сумын Засаг дарга |
| 32 | Их-Уул сумын хоёрдугаар цэцэрлэгийн складны өрөөг тохижуулж шинээр булаг байгуулах | 2024 | 2024 | 40,000.0 | Их-Уул сумын Засаг дарга |
| 33 | Цагдаагийн алба хаагчдыг торгуулийн багаж, хэвлэгч, тоног төхөөрөмжөөр хангах | 2024 | 2024 | 42,000.0 | Цагдаагийн газар |
| 34 | "Жалханз хутагт Ц.Дамдинбазар"-ын 150 жилийн ойд зориулж дурсгалт цогцолбор байгуулах | 2024 | 2024 | 300,000.0 | Улиастай сумын Засаг дарга |
| 35 | Асгат сумын ЕБС-д компьютерийн лаборатори байгуулах | 2024 | 2024 | 52,000.0 | Асгат сумын Засаг дарга |
| 36 | Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын байгаль хамгаалагчдыг унаажуулах | 2024 | 2024 | 24,500.0 | Тосонцэнгэл сумын Засаг дарга |
| 37 | Арц суурийн хилийн боомтод халуун усны барилга барих | 2024 | 2024 | 110,000.0 | Тэс сумын Засаг дарга |
| 38 | Тосонцэнгэл сумын 2-р сургуулийн спорт заалны дээврийг засварлахад шаардагдах барилгын материал нийлүүлэх | 2024 | 2024 | 54,000.0 | Тосонцэнгэл сумын Засаг дарга |
| 39 | Эрдэнэхайрхан сумын гэр хорсололд цэвэр ус, дулааны шугам татах | 2024 | 2024 | 200,000.0 | Эрдэнэхайрхан сумын Засаг дарга |
| 40 | Эрдэнэхайрхан сумын ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх тоноорөмж суурилуулах | 2024 | 2024 | 80,000.0 | Эрдэнэхайрхан сумын Засаг дарга |
| 41 | Улиастай сумын Чигэстэй голын гүүрнээс Цагдаагийн газрын урьд байрлах пункит хүртэлх төв цэвэр, бохир усны шугамын засварлах | 2024 | 2024 | 60,200.0 | Улиастай сумын Засаг дарга |
| 42 | Тэлмэн сумын соёлын төвийн барилгад их засвар хийх | 2024 | 2024 | 150,000.0 | Тэлмэн сумын Засаг дарга |
| 43 | Тэлмэн сумын жишиг хороололд 0.4 кВ-ын 4 км ЦДАШ-ын өргөтгөл хийх | 2024 | 2024 | 120,000.0 | Тэлмэн сумын Засаг дарга |
| 44 | Нөмрөг сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх | 2024 | 2024 | 100,000.0 | Нөмрөг сумын Засаг дарга |